



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/694

Улаанбаатар хот


Тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Торгон шир бэлтгэл ХХК-ийн 2024 оны 24/04/43 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн тушаах нь:

1.Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын бус байранд хадгалсан зөрчил арилсан нь Салбарын хяналтын газрын гүйцэтгэлийн шалгалтын дүнгээр тогтоогдсон тул Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/56 дугаартай тушаалаар "Торгон шир бэлтгэл" ХХК-д олгосон химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2.Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийг сэргээсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны "Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай" А/448 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Б.Мөнхтогтох), Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар (Г.Энхмөнх)-т тус тус үүрэг болгосугай.



С.ОДОНТУЯА

152400338

Батлав:

_____ / Г.ЭНХМӨНХ /
БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодолгын
хэрэгжилтийн газрын дарга

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

_____ /Ж.Алтанчимэг/
"Торгон шир бэлтгэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал



**УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р ХОРООНЫ
НУТАГТ ОРШИХ МАЛЫН АРЬС НЭХИЙНЭЭС ҮСИЙГ ГЭМТЭЭЛГҮЙГЭЭР
ХУУРАЙ ТЕХНОЛОГИЙН АРГААР САЛГАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6675522/

Хянасан:

ХБОБЗГ-ын шинжээч _____ / _____ /

Боловсруулсан: "Торгон шир бэлтгэл" ХХК-ийн

байгаль орчны мэргэжилтэн _____ /С.Долгорсүрэн/

2024 он

Агуулга

1	малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	1
1.1	Төслийн танилцуулга	1
1.2	Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи	3
1.3	Үйлдвэрийн талбай, барилга байгууламж	5
1.4	Химийн бодисын нэр төрөл, зарцуулалт	8
1.5	Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж	8
1.6	Усан хангамж.....	9
2	Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	12
2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	12
2.2	Уур амьсгал	12
2.3	Агаарын чанар	17
2.4	Физик бохирдол.....	19
2.5	Геологийн тогтоц ба геоморфологи	20
2.6	Газрын доорх ус.....	22
2.7	Хөрсөн бүрхэвч.....	22
2.8	Ургамлан нөмрөг	23
2.9	Амьтны аймаг	23
2.10	Тусгай хамгаалалттай газар нутаг	23
2.11	Түүх, соёлын өв.....	24
2.12	Нийгэм, эдийн засаг	24
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	26
3.1	Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	26
3.2	Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	26
3.3	Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	26
3.4	Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.5	Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.6	Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.7	Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.8	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.9	Дуу шуугианаас үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.10	Нийгэм, эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	28
3.11	Түүх, соёлын өвд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	28
4	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	29
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30
6	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	36
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	37
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	38
8.1	Баримтлах эрх зүйн баримт бичиг.....	38
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	41
10	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	43
11	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө.....	45

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал	3
Хүснэгт 2: Химийн материалын тооцоо, жилээр	3
Хүснэгт 3: Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт ашиглах химийн бодисын нэр, төрөл, жилд ашиглагдах хэмжээ.....	8
Хүснэгт 4: Хатуу хог хаягдлын тооцоо	10
Хүснэгт 5: Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанар /2020 оны 10-р сараас 2022 оны 4-р сар/.....	17
Хүснэгт 6: Судалгааны талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүн.....	18

Хүснэгт 7: Судалгааны талбайн ойролцоо орших улсын тусгай хамгаалалттай газруудын мэдээлэл	23
Хүснэгт 8: 2023-2027 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ	29
Хүснэгт 9: 2024 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ	29
Хүснэгт 10: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 он.....	30
Хүснэгт 11: Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө, 2023-204 он.....	36
Хүснэгт 12: Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, 2024 он.....	39
Хүснэгт 13: Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө, 2024 он.....	41
Хүснэгт 14: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн” төслийн 2024 онд хэрэгжүүлэх ОХШХ	43
Хүснэгт 15: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр” төслийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	45

Зургийн жагсаалт

Зураг 1: Үйлдвэрийн талбайн байршил	2
Зураг 2: Төслийн талбайн байршлын агаар сансрын зураг	2
Зураг 3: Үйлдвэрийн байрны харагдах байдал	5
Зураг 4: Оффисын өрөөнүүдийн дотоод зохион байгуулалт	6
Зураг 5: Ариун цэврийн өрөөний зохион байгуулалт	6
Зураг 6: Ажилчдын хувцас солих, амрах өрөөний зохион байгуулалт.....	7
Зураг 7: Үйлдвэрийн байрны дотоод зохион байгуулалт	7
Зураг 8: Намаз /Уусмал/ бэлтгэх хэсэг.....	8
Зураг 9: Самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухны зохион байгуулалт	9
Зураг 10: Хог түр хадгалах бункерийн байршил	10
Зураг 11: Үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс гарах бохир хуримтлуулах цооног	11
Зураг 12: Судалгааны талбайн түүний орчмын физик газарзүй	12
Зураг 13: Улаанбаатар хотын климаграмм	13
Зураг 14: Агаарын дундаж температурын явц, сараар.....	13
Зураг 15: Хөрсний гадаргын дундаж температурын явц, сараар	14
Зураг 16: Харьцангуй чийгшлийн явц, сараар	14
Зураг 17: Жилийн нийлбэр хур тунадасны явц.....	15
Зураг 18: Хур тунадасны явц, сараар	15
Зураг 19: Агаарын даралтын явц, сараар	16
Зураг 20: Салхины дундаж хурдны явц, сараар.....	16
Зураг 21: Агаарын чанарын хэмжилт хийсэн байршил	18
Зураг 22: PM2.5 тоосонцрын хэмжилтийн үр дүн.....	18
Зураг 23: PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн.....	19
Зураг 24: NO2-ын хэмжилтийн үр дүн	19
Зураг 25: Судалгааны талбай түүний орчмын геологийн зураг.....	21
Зураг 26: Улаанбаатар хот орчимд 2005-2015 онд бүртгэгдсэн газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд ба газар хөдлөлт бүртгэгдсэн цэгүүд	22

1 МАЛЫН АРС, НЭХИЙНЭЭС ҮСИЙГ ГЭМТЭЭЛГҮЙГЭЭР ХУУРАЙ ТЕХНОЛОГИЙН АРГААР САЛГАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1 Төслийн танилцуулга

Торгон шир бэлтгэл ХХК-ийн малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 8615 м2 газарт оршино.

Малын арьснаас хуурай аргаар үс салгах технологи нь уламжлалт технологитой харьцуулахад 2 дахин үр ашигтай байсан тул 2024 онд үйл ажиллагаа явуулахаар холбогдох зөвшөөрлүүдийг авсан.

Хуурай технологи нь уламжлалт технологитой харьцуулахад 2 дахин цөөн үйлдвэрийн шат дамжлагатай бөгөөд дэвтээлгийн үс шат байхгүй тул дэвтээлгийн үс ашиглагдахгүйгээс гадна арьснаас үс салгах бодисын хэрэглээний хувьд уламжлалт технологиос 88 хувиар бага бодис ашиглагддаг. Уламжлалт технологитой I үйлдвэр арьс боловсруулах улирал буюу 11 сараас 5 сарыг дуустал нийт 7 сарын хугацаанд дунджаар 350,000 арьс боловсруулж, 1,2 сая.кг бодис ашигладаг бол хуурай технологийн арга нь тухайн саруудад 1,050,000 арьс боловсруулж, 420 мянга.кг бодис ашиглагдах юм. Үүнээс дүгнэхэд инновацийн технологи болох хуурай арга нь эдийн засгийн өгөөжийг 2 дахин нэмэгдүүлж байна. Мөн нэгж арьсанд ногдох бодисыг 88 хувиар бууруулсан тул байгаль орчинд үүсгэх хог хаягдал, нөлөөллийг ижил хувиар бууруулж байна гэсэн логик дүгнэлт гаргаж болно. Энэхүү үр нөлөө нь Монгол улсын бодлого, эрх зүйн орчны хүрээнд 7 эрх зүйн баримт бичгийн 12 заалттай нийцэлтэй байгааг макро орчны шинжилгээгээр тодорхойлсон.

Инновацийн хуурай технологийн аргыг үйлдвэрүүдэд нэвтрүүлснээр богино хугацаанд огт гэмтэлгүй, хэвийн үргэлж ноосыг гаргаж авах ба арьсыг нь дахин боловсруулалтад ашиглах бүрэн боломжтой болох юм. Ингэснээр жил бүр хаягддаг 13.7 сая арьс болон 12 000 тн ноосыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Төслийн нэр: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр”


Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Торгон шир бэлтгэл” ХХК

Регистрийн дугаар: 6675522

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, 413а тоот. Утас: 88810054

Төслийн талбайн байршил

Малын арьс, арьс нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 8615 м2 газарт байрлана (Зураг 1).



Зураг 1: Үйлдвэрийн талбайн байршил



Зураг 2: Төслийн талбайн байршлын агаар сансрын зураг

1.2 Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи

Үйлдвэрийн хүчин чадал

Үйлдвэр нь өдөрт 4000 ширхэг богийн арьсны үсийг гэмтээлгүйгээр салган авч захиалагчийн шаардлагыг хангаж ажиллана. Үйлдвэр нь 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 05 дугаар сарын 30-ний өдөр дуустал календарийн 7 сарын хугацаанд ажлын 154 хоног ажиллана.

Арьс ширэн түүхий эд нь улирлын чанартай бэлтгэгддэг учир 06-10 саруудад үйлдвэр ажиллахгүй. Энэ хугацаанд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгаа, шинжилгээ, туршилтын ажлууд хийгдэнэ.

Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал

Түүхий эд	Хоногийн хүч чадал, ш	Жилд ажиллах хоног	Жилийн хүч чадал, мян.ш	Бүтээгдэхүүн, тн	Ажиллагсдын тоо, хүн
Богийн арьс	4000	154	616	2146	44

Үйлдвэрийн технологи

Захиалагчаас нийлүүлсэн арьсыг тоолж үйлдвэрлэлд шууд хүлээн авах ба үсийг сулруулах зориулалттай, урьдчилан бэлтгэсэн уусмалаар шар махан талаас нь шүршээд шүршсэн талаар нь нийлүүлж хавсран 4 цаг орчим хэвтүүлэх ба суларсан үс, ноосыг үслэх машинаар эсвэл гар аргаар салгаж авна.

Энэхүү үс салгах хуурай, технологи нь олон улсад ялангуяа Австрали улсад өргөн хэрэглэгддэг hair save unhairing-limiting болон Америк, Испанид өргөн судлагдсан Enzymatic unhairing технологиудыг компанийн судалгаа, туршилтуудын үндсэн дээр сайжруулж, шинээр гаргаж авсан, үсийг авахад заавал дэвтээх, махлах зэрэг ажиллагаа шаарддаггүй, хуурай арьсан дээр шууд хэрэглэдэг технологи юм.

Арьс ширний үсийг сулруулах уусмал нь нэгдүгээр зэргийн бөсгөсөн шохой, хүхэрт натри (Na_2S)-ийн 65%-иас багагүй идэвхтэй болон протезын идэвхт энзим байна.

Энэ аргаар салгаж авсан үс /ноос, ноолуур, хөөвөр, хялгас/-ны химийн болон гистологийн бүтцэд ямар ч гэмтэл, эвдрэл гардаггүй бөгөөд ашигласан уусмал нь байгаль, орчин хүний бие организмд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Өдөрт хонины 3000-4000 ш, жилд 0.62 сая нэхийний ноос авахад хэрэглэх түүхий эд, материалын хэрэгцээг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2: Химийн материалын тооцоо, жилээр

Дамжлага	Химийн материал	Орц, %	Хэрэгцээ, тн
Үс сулруулалт	Хүхэрт натри	0.6	46.2
	Шохой	1.5	115.5
/намаз бэлтгэх/	Ус	8.6	215.6
	Энзим, бактери	0.01	0.8
Дүн		10.7	377.9

Бүтээгдэхүүний хяналт

Бүтээгдэхүүний хяналт нь дараах шаттай явагдана. Бүтээгдэхүүн, технологийн хяналтыг ерөнхий технологич зохион байгуулна.

Үйлдвэр нь арьс ширэн түүхий эд бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулж түүхий эдийн нийлүүлэлтийг ханган ажиллана. Бэлтгэн нийлүүлэлтийн гэрээнд түүхий эдэд болон чанарын хамгаалалтад тавигдах стандартын шаардлагыг заавал тусгаж өгнө.

Түүхий эд бэлтгэгч нь түүхий стандартын шаардлага хангасан түүхий эдийг хүлээн авна. Дулааны улиралд бэлтгэгдсэн түүхий эд нь Чанарын хамгаалалт хийх арга. MNS 0060 : 2001 стандартын шаардлага хангасан байна. Хүйтний улиралд зохих стандартын дагуу хөлдөөж хадгалсан байна. Түүхий эдийг үйлдвэрийн түүхий эдийн мэргэжилтэн, чанар шалгагч эсвэл технологич зохих журмын дагуу, тоолж хүлээж авна.


Түүхий эд бэлтгэлийн чиглэлээр баримтлах стандартууд :

- Түүхий эд бэлтгэл. Боловсруулаагүй арьс шир. Техникийн шаардлага. MNS 0060 : 2013
- Түүхий эд бэлтгэл. Арьс ширэнд чанарын хамгаалалт хийх аргууд. MNS 5094 : 2013
- Арьс ширэн түүхий эдийн гэмтлийн нэр томьёо, тодорхойлолт. MNS 3121 : 2001

Стандартын дагуу бэлтгэгдсэн арьс ширэн түүхийг эдийн үйлдвэрийн чанар шалгагч шалгаж тоолж хүлээж авах ба MNS 3121 : 2001 стандартын дагуу гэмтлийг тодорхойлж шаардлага хангаагүй түүхий эдийг хаягдал боловсруулах хэсэг руу шилжүүлнэ. Шаардлага хангасан түүхий эдийг технологийн боловсруулалтад шилжүүлнэ.

Технологийн үйл ажиллагаа - хяналт

Арьс ширнээс ноос үсийг салгах үйл ажиллагаа нь дараах зургийн дагуу явагдана.



- А. Түүхий эд хүлээж авах, бэлтгэх -стандартын дагуу бэлтгэгдсэн түүхий эдийг намазлахад бэлдэн, гэсгээн, хатсан хэсэг байвал чийглэж, шар махан талыг дээш харуулан бэлдэнэ.
- В. Үс салгах технологи ажиллагаа-тусгай жорын дагуу бэлдсэн үс сулруулах түрхлэгийг шар махан талаас нь түрхэж, шингэсний дараа зооны шугамын дагуу хавсран хураана. 4-5 цагийн дараа үсийг салгана.
- С. Үс ноос, арьсыг дараагийн боловсруулалт руу шилжүүлэх

Технологийн боловсруулалтад ирсэн түүхийн эдийг чанар шалгагч цехийн мастер болон технологичид хүлээлгэн өгсний дараа үс салгах үйл ажиллагаа эхэлнэ. Үс салгах үйл ажиллагаа нь технологи эхлэхээс өмнө дараах байдлыг хангасан байна.Үүнд:

- а. Технологийн үйл ажиллагааг технологич удирдан явуулна.

- в. Тухайн түүхий эдийг боловсруулах технологийг тодорхойлж, боловсруулж батлуулсан байна- технологийн карт;
- с. Технологийн орц нормыг нарийн тооцож, зохих хяналтыг хийсэн байна.
- д. Химийн материал, түүхий эдийн нөөц, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах;
- е. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

Технологийн дамжлагын хяналтын үйл ажиллагаа

- а. Боловсруулах үйлдвэр нь дотроо технологийн дамжлагын хяналтын хэсэгтэй байна.
- б. Дамжлагын явцад технологийн параметруудийг хянаж шаардлагатай технологийн шинжилгээг хийнэ.
- с. Дамжлагын хяналт нь үйл ажиллагааны журамтай байх, байгууллагын болон MNS стандартын аргачлалын дагуу шинжилгээ хийнэ.
- д. Шинжилгээнд хэрэглэгдэх уусмалыг аргачлалын дагуу мэргэжлийн хүн бэлтгэж, засварын факторыг тогтоосон байна.
- е. Шинжилгээг чанар шалгагч эсвэл лаборант хийж, технологич хянаж технологийг тохируулна.
- ф. Дамжлагын лабораторийн хяналтыг "лабораторийн шинжилгээний тэмдэглэл" ийн дагуу хийж баримтжуулна.

Бэлэн бүтээгдэхүүний хяналт

Боловсруулах үйлдвэрийн хувьд бүтээгдэхүүнүүд нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. Хуурай технологийн аргаар салгасан үс ноос : хонины ноос, үхрийн хөөвөр, ямааны ноолуур, тэмээний ноос
2. Нүцгэн арьс: хуурай технологийн аргаар үс ноосыг нь салгасан арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний хяналтад шаардлагатай стандартууд :
 - Арьс шир. Лабораторийн шинжилгээнд хамрагдах дээжийн тоог тодорхойлох. 3272:1990
 - Арьс шир. Талбай хэмжих арга. MNS 2369:2001
 - Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал. Зумласан ноос. Техникийн шаардлага. MNS 5251:2008,
 - Бүх төрлийн ноос, ноолуур, ширхэгт материалыг баглах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журам. MNS 215:2001
 - Арьс шир. Желатин, цавуу, малын уурагт тэжээлийн түүхий эд. Техникийн шаардлага MNS 3348:2003.

Эцсийн бүтээгдэхүүний хяналтыг хийхдээ хамтын ажиллагааны хүрээнд итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллана.

1.3 Үйлдвэрийн талбай, барилга байгууламж

Үйлдвэрлэлийн байгууламж нь 84 м урт, 16 м өргөн, 9 м өндөртэй, 1635 м² талбайтай,




Зураг 3: Үйлдвэрийн байрны харагдах байдал

Үйлдвэрийн барилга дотор оффис, ажилчдын хоолны газар, ажиллагсдын хувцас солих, амрах өрөө, ариун цэврийн болон бойлерын өрөөнүүдтэй



Зураг 4: Оффисын өрөөнүүдийн дотоод зохион байгуулалт



Зураг 5: Ариун цэврийн өрөөний зохион байгуулалт



Зураг 6: Ажилчдын хувцас солих, амрах өрөөний зохион байгуулалт

Харуул, хамгаалалтын байртай, эдгээр нь үйлдвэрлэлийн барилгын хамт самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухаар халаана.

Хатуу хог, хаягдлын цэгтэй, үйлдвэрийн барилгын талбайн 20%-иос багагүй хувь нь ногоон байгууламжтай байхаас гадна шөнийн гэрэлтүүлэгтэй, үйлдвэрийн дотор, гадна орчны камержуулалт, дохиолол, харуул хамгаалалтын системтэй байна.

Усгүй технологиор үйлдвэрлэл явуулах учраас шингэн хаягдал гарахгүй бөгөөд, бохирыг зайлуулах суваг, шуудуу, цэвэрлэх байгууламж шаардагдахгүй.



Зураг 7: Үйлдвэрийн байрны дотоод зохион байгуулалт

Үйлдвэрийн барилга нь сэндвичэн бүтээцтэй, дулааныг гадагш алдагдуулахгүй байх технологи ашигласан байна.

1.4 Химийн бодисын нэр төрөл, зарцуулалт

Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт 3 нэр төрлийн химийн бодис ашиглана (Хүснэгт 3). Үйлдвэрт ашиглах химийн бодисуудыг "Империал партнерс" ХХК-аас нийлүүлнэ.

Хүснэгт 3: Малын арьс нэхийнээс үсийг хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт ашиглах химийн бодисын нэр, төрөл, жилд ашиглагдах хэмжээ

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	CAS дугаар	Хэмжээ, тн (1 жилд)
1	Бөсгөсөн шохой	Hydrate lime	Ca(OH) ₂	1305-62-0	115
2	Хүхэрт натри	Sodium sulfide	Na ₂ S	1313-82-2	43
3	Энзим бактери	EVICON-CNS, Antibacterial, Antifungal and other VOCS removers	-	Хольц	0.8



Зураг 8: Намаз /Уусмал/ бэлтгэх хэсэг

1.5 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбайд 6кв/0.4кв-ын цахилгааны дэд станцтай бөгөөд мэргэжлийн байгууллагаар зураг төсвийн дагуу монтаж хийлгэхээр төлөвлөсөн. Үйлдвэрийн ТЭЗҮ-д тооцоолсноор жилд дунджаар 12,320 кВт цахилгаан зарцуулна.

Төлөвлөж буй үйлдвэр нь уурын зуухаар үйлдвэрийн барилга байгууламжийг халаана. 11 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл галлахаар төлөвлөсөн.



Зураг 9: Самрын яс түлдэг бага оврын халаалтын зуухны зохион байгуулалт

1.6 Усан хангамж

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг ("Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан **"Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"**-ын 14 дугаар хавсралт "Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм"-д зааснаар албан байгууллага /захиргааны барилга/ 1 ажилтны хоногийн дундаж усны хэрэглээ) **80 литрээр** тооцлоо. Бүрэн хүчин чадлаараа хамгийн ихдээ 44 хүн ажиллана гэж үзэн, төслийн ажиллах хугацаа /жилийн 11-5 сарын хугацаанд 154 хоног/-нд:

- Ажилчид $44 \text{ хүн} * 80 \text{ л} = 3520 \text{ л}$ буюу $3.5 \text{ м}^3/\text{хон}$
Жилд $154 \text{ хоногт} * 3.5 \text{ м}^3/\text{хон} = 542.1 \text{ м}^3/\text{жил}$,

Үйлдвэрийн талбайд нийт 30 ш суулгац тарих ба 13 дугаар хавсралт "Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм"-д зааснаар 1 ш суулгац услахад **40 литр** ус зарцуулна /жилийн 5-10 сарын хугацаанд 6 удаа/-нд:

- $30 \text{ ш суулгац} * 40 \text{ л ус} * 6 \text{ удаа} = 7.2 \text{ м}^3/\text{ус}$

Үйлдвэрийн технологид 1 ш арьсанд 0.35 л ус. Хоногт 4000 ш арьсанд 1400 л, жилд (154 хоног) 215.6 ус орно.

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардагдах нийт усны хэмжээ жилд 764.9 м^3 .

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбайд 120 м гүн өрмийн худаг байрлах усны тогтоосон түвшин 18 метр, цоногийн ашиглалтын усны ундарга 84 метр, шүүрийг 40-120 метрийн гүнд суурилуулсан байна. Төслийн талбайн гүний худгийн байршлыг доорх зурагт үзүүлэв.

Хог хаягдал

Хог хаягдлыг ерөнхийд нь аливаа үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд шууд нийцэхгүй болсон материал гэж тодорхойлдог (OECD, 2003). Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад дор дурдсан гарал үүсэлтэй хог хаягдал гарна. Үүнд:

- Ахуйн гаралтай хаягдал
- Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал

Ахуйн гаралтай хог хаягдал

Хатуу хог хаягдал

Ахуйн гаралтай хог хаягдалд үйлдвэрийн ажилчдын хэрэглээнээс гарах хоолны үлдэгдэл, цэнэг хураагуур, хаягдал цаас, хайрцаг, шилэн сав, лонх, хуванцар сав, хуванцар эдлэл, даавуун болон нийлэг эдлэл гэх мэт хаягдлууд орно.

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрт 44 хүн ажиллана.

Хүснэгт 4: Хатуу хог хаягдлын тооцоо

Нийт хоног/жилд ажиллах хоног,	Ахуйн хог хаягдал, кг	Нийт хүний тоо	Нийт, кг/жил
154	0.5	44	3388 кг

Дээрх хүснэгтээс харахад үйлдвэрийн ажилчдаас жилд ойролцоогоор 3.4 ахуйн хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хог хаягдлыг Сонгинохайрхан дүүрэгтэй хог ачилт, тээвэрлэлтийн гэрээ хийн тогтмол хугацаанд ачуулах ба тухайн газрын зөвлөсөн хогны бункерийг хашаандаа байрлуулсан.



Зураг 10: Хог түр хадгалах бункерийн байршил

Үс, ноос салгаж авсан арьсаа цаашид арьс, шир боловсруулах үйлдвэр, цавууны үйлдвэр, муур, нохойны хоолны үйлдвэр зэрэг үйлдвэрүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байна. Иймээс үйлдвэрийн хог хаягдал гарахгүй.

Шингэн хог хаягдал

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн ажилчдын ахуйн шингэн хаягдал, ажилчдын гал тогооноос үүсэх ахуйн бохир ус зэрэг шингэн хаягдлууд үүснэ.

Ажилчид унд ахуйн хэрэгцээнд хоногт нийт 3.5 м³ ус хэрэглэнэ. Үүнээс 100%-ийг хаягдал ус гэж үзвэл: Жилд 3.5 м³/хоног * 154 хоног = 539 м³/жил болно.

Үйлдвэр нь ахуйн хэрэгцээнээс гарах бохирыг өөрийн урсгалаар гаднах 50 тн 2 ширхэг бохир хуримтлуулах ёмскт хуримтлуулна.

Ахуйн хэрэгцээнээс үүсэх бохирыг бохир соруулах үйлчилгээ үзүүлэгч компанитай гэрээ хийн зайлуулахаар төлөвлөсөн. Уг хаягдал уснаас уснаас дээж авч шинжлүүлэх шаардлагатай бөгөөд Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж – MNS ISO 5667-10:2001 стандартын дагуу аван магадлан итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлнэ.



Зураг 11: Үйлдвэрийн ажилчдын хэрэгцээнээс гарах бохир хуримтлуулах цооног

Химийн бодисын сав, баглаа боодлын хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх химийн бодисын сав баглаа боодол болон хэрэглэгчдээс дахин ашиглах боломжтой савыг эргүүлэн авч химийн бодисын хог хаягдлыг устгах, боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий “Элемент” ХХК-д нийлүүлнэ.

БАТЛАВ ХХК
“ЭЛЕМЕНТ” ХХК-ийн
ГҮЙЦЭГТЭХ ХАМРАЛ
УЛААНБААТАР

БАТЛАВ
“ТОРГОН ШИР БЭЛТГЭГ” ХХК-ийн
ГҮЙЦЭГТЭХ ХАМРАЛ
УЛААНБААТАР

**ХИМИЙН ХОРТОН БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ХАЯГДАЛ ГЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭГТЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-24/006
24/06/03

2024 оны 01-р сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЭЛ

1. Нэг талаас “Элемент” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа нөгөө талаас /цаашид захиалагч гэх/ “Торгон шир бэлтгэгч” ХХК-ийг төлөөлж ерөнхий нягтлан бологч албан тушаалтай Р.Мөнхчимэг бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүд мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэстэн энэхүү гэрээг байгуулав.


1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шалгах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд өгч гэрээлэх, устгахад оршино.

1.2. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж харилцалыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Судалгааны талбайн баруун урд, баруун, зүүн хойд, зүүн болон урд хэсгээр Баян цогт овоо уул, Эмээлт уул, нэргүй өндөрлөг уулс хүрээлэн оршино. Тэдгээр уулсын өндрийн хэмжээ дтд 1463-1564 м хүрэх ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим хэсгээр 30-35 хэм хүрнэ. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.




Зураг 12: Судалгааны талбайн түүний орчмын физик газарзүй

Үйлдвэрийн талбай нь аж ахуйн машин техник, арьс ширний агуулахын барилга байгууламж баригдах, хүний нөлөөгөөр газрын гадаргын байгалийн төрх өөрчлөгдөж, эвдэрсэн. Тус талбайн нь тэгшивтэр гадаргуутай ба дтд 1373-1375 м өндөртэй.

2.2 Уур амьсгал


Улаанбаатар хот нь Монгол орны нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай, тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Зундаа хуурайдуу сэрүүн, өвөлдөө хахир хүйтэн байдаг. Улаанбаатар станцын 1980-2022 оны цаг агаарын ажиглалтын мэдээнээс үзэхэд Улаанбаатар хотын жилийн дундаж агаарын температур 0.3°C , хөрсний гадаргын дундаж температур 1.3°C байна. Агаарын харьцангуй чийгшил дунджаар 61.1%, жилд унах нийт хур тунадасны хэмжээ дунджаар 287.2 мм хүрдэг (Зураг 13). Улаанбаатар хотын салхины дундаж хурд 2.3 м/с байдаг.



Зураг 13: Улаанбаатар хотын климаграмм

Улаанбаатар станцын мэдээгээр хавраас бусад улиралд зүүн зүгийн салхи зонхилдог. Салхины зонхилох чиглэл зүүнээс 26.1%, баруун хойноос 19.1% байна¹.

Агаарын температур: 1980-2022 оны ажиглалтын мэдээгээр Улаанбаатар хотын агаарын дундаж температур 0.3°C, үнэмлэхүй хамгийн бага температур -39.8°C (2001.01.09), үнэмлэхүй хамгийн их температур 38.3°C (2010.06.26) хүрдэг. Агаарын дундаж температур 1-р сард -21.4°C, 7-р сард 18.4°C байдаг (Зураг 14).




Зураг 14: Агаарын дундаж температурын явц, сараар

Газрын гадаргаас дээш хөөрсөн агаар дэлхийн агаар мандлын доод давхаргад эзлэхүүнээ тэлж, температур нь буурдаг ерөнхий зүй тогтолтой. Гэвч зарим тохиолдолд эсрэгээрээ дээшлэх тусам агаарын температур нэмэгддэг. Үүнийг температурын инверс буюу тонгоруу гэдэг. Өөрөөр хэлбэл, халуун агаар нь доороо байх хүйтэн агаарыг дээшлүүлэлгүй "түгжих" үзэгдэл юм. Ийм учраас өвлийн улиралд инверсийн давхарга доод хэсгийн агаарыг дээшээ сэлгээнд оруулалгүй хотын

¹ Д.Даваадорж, Б.Энхтуяа, Улаанбаатар хотын бичил уур амьсгалын судалгааны асуудал


олон эх үүсвэрээс бий болох бохирдлыг тогтоон барьдаг (Өвлийн улирлын агаарын чанарын төлөв байдлын тухай Агаарын чанарын бүлгээс дэлгэрүүлж үзнэ үү).

Хөрсний температур: Улаанбаатар хотын 1980-2022 оны хөрсний гадаргын жилийн дундаж температур 1.3°C байна. Хөрсний гадаргын дундаж температур 7-р сард 22.6°C, 1-р сард -24.5°C байна (Зураг 15).




Зураг 15: Хөрсний гадаргын дундаж температурын явц, сараар

Агаарын чийгшил: 1980-2022 оны Улаанбаатар хотын агаарын харьцангуй чийгшил дунджаар 61.1% байна. Агаарын харьцангуй чийгшлийн хамгийн их утга нь өвлийн улиралд, харин хамгийн бага утга нь хаврын улиралд ажиглагддаг (Зураг 16).




Зураг 16: Харьцангуй чийгшлийн явц, сараар

Хур тунадас: Улаанбаатар станцын 1980-2022 оны хур тунадасны мэдээнээс үзэхэд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ дунджаар 287.2 мм байна (Зураг 17).




Зураг 17: Жилийн нийлбэр хур тунадасны явц

Улаанбаатар хотод зуны улиралд дунджаар 190.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 69.9% нь унадаг (Зураг 18).



Зураг 18: Хур тунадасны явц, сараар


Агаарын даралт: Улаанбаатар хотын агаарын дундаж даралт 868.2 гПа, 1-р сард 871.9 гПа, 7-р сард 862.9 гПа байдаг (Зураг 19).



Зураг 19: Агаарын даралтын явц, сараар

Агаарын даралтын хамгийн их утга нь өвлийн сарууд, хамгийн бага утга нь зуны саруудад тохиолддог.

Салхины горим: Улаанбаатар хотод салхины дундаж хурд 2.3 м/с хүрдэг. Салхины дундаж хурдны явцаас авч үзвэл 4-6-р сард хамгийн их утга авдаг (Зураг 20).



Зураг 20: Салхины дундаж хурдны явц, сараар

Улаанбаатар станцын хувьд зүүн /26.1%/ болон баруун хойд /19.1%/ зүгийн салхи зонхилдог².

² Д.Даваадорж, Б.Энхтуяа, Улаанбаатар хотын бичил уур амьсгалын судалгааны асуудал

2.3 Агаарын чанар

Улаанбаатар хотын гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодисууд болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5 тоосонцор (жижиг ширхэглэгт тоосонцор), PM10 тоосонцор (том ширхэглэгт тоосонцор), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар хэмждэг.

Хүснэгт 5: Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанар /2020 оны 10-р сараас 2022 оны 4-р сар/

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2020-10-р сараас 2021 оны 4-р сарын дундаж	2021 оны 10-р сараас 2022 оны 4-р сарын дундаж
PM2.5 тоосонцор	50	60	65 (8%↑)
PM10 тоосонцор	100	107	122 (14%↑)
Хүхэрлэг хий, NO ₂	50	42	51 (21%↑)
Азотын давхар исэл, SO ₂	50	112	100 (11%↓)

Эх сурвалж: Цаг уур орчны шинжилгээний газар, Орчны шинжилгээний хэлтэс. Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал (хүйтний улирал буюу 2021 оны 10-р сараас 2022 оны 4-р сар)-ын тойм.

Тайлбар: Өмнөх онтой харьцуулахад ↓ бага; ↑ их;

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотод 2020-2022 оны хүйтний улирал (2020 оны 10-р сараас 2022 оны 4-р сар)-д агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад PM2.5 тоосонцор 5 мкг/м³-ээр (8%), PM10 тоосонцор 15 мкг/м³ (14%)-ээр, азотын давхар исэл 9 мкг/м³ (21%)-ээр тус тус их, харин хүхэрлэг хий 12 мкг/м³ (11%)-ээр багасчээ.

Улаанбаатар хотын хүйтний улиралд агаар бохирдуулах гол бодисуудын агууламжийг тус бүрт нь

Үйлдвэрийн талбайн агаарын чанар

Торгон шир бэлтгэл ХХК-ийн малын арьс нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр салгах үйлдвэрийн талбайд 2023 оны 10-р сарын 11-нд агаар дахь PM2.5, PM10 тоосонцрууд, NO₂ буюу азотын давхар агууламжийг Aeroqual Series 500 маркийн багажийг ашиглан 1 цэгт хэмжилт хийсэн.




Зураг 21: Агаарын чанарын хэмжилт хийсэн байршил

Агаарын чанарын хэмжилтийн үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)-тай харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв (*Хүснэгт 6*).


Хүснэгт 6: Судалгааны талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүн

#	Байршил	Координат		NO2	PM2.5 мкг/м ³	PM10
		Өргөрөг	Уртраг			
1	Үйлдвэрийн талбайд	47 54 08.41	106 34 12.25	138	65	109
MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (NO2- 20 мин дундаж, PM2.5, PM10-24 цагийн дундаж)				200	50	100


Дээрх хүснэгтээс харахад PM10 тоосонцор болон PM2.5 тоосонцрын агууламж MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас PM2.5 1.3 дахин, PM10 1.1 дахин давсан үзүүлэлттэй байна. NO2-ын түвшин MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байна (*Зураг 22, Зураг 23, Зураг 24*).



Зураг 22: PM2.5 тоосонцрын хэмжилтийн үр дүн



Зураг 23: PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн



Зураг 24: NO2-ын хэмжилтийн үр дүн

2.4 Физик бохирдол

Дуу шуугиан

ДЭМБ-ын гаргасан лавлахад шуугианы түвшин суурьшлын орчинд 16 цагийн хугацаанд 50-55дБА, үйлдвэр, олон нийтийн үйлчилгээний газар, автозамын дагуу 24 цагийн турш 70дБА байхад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Эрүүл ахуйн үүднээс хүн өдөрт тасралтгүйгээр байж болох шуугианы зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоон мөрддөг.

Монгол Улсын MNS 4585:20161 стандартад заасанчлан өдрийн цагт 60 дБА (16 цагийн дунджаар), шөнийн цагаар 45 дБА (8 цагийн дунджаар)-аас хэтрүүлэхгүй байх ёстой бол Олон улсын IFC2 стандартад зааснаар гадаад орчны дуу чимээ өдрийн цагаар 55 дБА, шөнийн цагаар 45 дБА-аас давахгүй байхыг заасан байдаг. Мөн ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй хөдөө нутагт дуу шуугианы түвшин дунджаар 30 дБА3 байдаг.

Монгол улсад анх 1996 онд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн гадаад орчны дуу шуугианыг судлахад Улаанбаатар хотын гудамжны дуу шуугианы дундаж түвшин (ДШДТ) 71дБА байсан. Түүнчлэн 2003 оны Монгол улсын томоохон хотуудын дуу шуугианы түвшингийн судалгаагаар дундаж түвшин 63.6 дБА байсан ба УБ хотын төв гудамжны дуу шуугианы оргил үе нь 08-09 цагт байна /НЭМХ, 2003/. Дуу шуугианы түвшин өндөртэй орчинд олон жил амьдарсан болон ахицаж настай хүмүүс дуу шуугианд илүү өртдөг бөгөөд үүнд авто машинаас гарах дуу шуугиан их нөлөөлдөг нь тогтоогдсон байна.

Хэвийн хэмжээнээс хэтэрсэн дуу шуугиан нь хүний сонсгол болон тархины эд эсүүдийг гэмтээж, төв мэдрэлийн системд нөлөөлснөөр түргэн ядрах, анхаарал сулрах, нойргүйдэж улмаар зүрх судасны үйл ажиллагаанд өөрчлөлт орж, даралт ихсэх, зүрхний шигдээс өвчний эрсдэлийг нэмэгдүүлэх, бодисын солилцоо болоод ходоод гэдэсний хэвийн ажиллагаа алдагдах зэргээр хүний эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Судалгааны талбайд тогтмол дуу шуугианы эх үүсвэр байхгүй бөгөөд харин талбайн зүүн хойд талаар 50 м зайд байрлах Улаанбаатар - Өвөрхангай чиглэлийн авто замаар зорчих тээврийн хэрэгслээс шуугианы нөлөөлөл үзүүлж болно. Барилгажилтын үед ажиллах машин механизм, техник хэрэгслээс дуу шуугиан үүсэж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хог хаягдал

Үйлдвэрийн талбайд одоогийн байдлаар арьс шир хадгалах зориулалттай агуулахын барилга баригдсан байна. Энгийн хатуу хог хаягдлыг судалгааны талбайд байрлах хогийн цэгт түр байршуулдаг. Өөрийн эзэмшлийн талбай болон ойр орчмын талбай нь хог хаягдлаар бохирдоогүй байв.

2.5 Геологийн тогтоц ба геоморфологи

Геологийн тогтоц


Улаанбаатар хот орчмын бүс нутагт карбон, доод цэрд, неогены тунамал болон дөрөвдөгчийн үеийн сэвсгэр хурдас, түүнчлэн дээд юрагийн гүний шургамал чулуулаг зонхилон тархсан. Туул голын хөндийн ай савын хоёр талын хажуу жигүүрийн уулархаг массивын хэмжээнд карбоны настай шаварлаг зануужин болон жижиг-дунд ширхэгтэй нилээд хувирч кварцжсан элсжингийн флишлэг бүтэцтэй зузаалаг тархсан байна. Энэхүү зузаалгийн геологийн зүсэлтийн зарим хэсэгт улаан хүрэн өнгийн хас, бөсөл, бөсөлжин болон гантигжсан шохойжингийн харьцангуй жижиг мишэл биет, багц үеүд түгээмэл ажиглагддаг. Сул барьцалдсан хайргажин мөлгөр хөрзөнгийн нимгэн үе, үелэл бүхий доод цэрдийн шаварлаг хурдас зөвхөн Толгойтын голын хөндийн зүүн урд жигүүрийн харьцангуй өргөгдсөн блок хэсэгт нилээд хязгаарлагдмал хэлбэрээр тархсан байна.

Баруун-Зүүн Нарангийн энгэр, Гандангийн дэнж, Шархад, Улаан хуаран, Ногоон нуур, Дэнжийн мянга, Улиастайн голын адгийн садарга орчимд зонхилон тархсан неогены шаварлаг хурдасны зузаалгийн литологийн бүрэлдүүнд ихэвчлэн тоосгон улаан, улбар бор шарга өнгийн нягт шаврын багц давхарга давамгайлдаг бөгөөд хааяа янз бүрийн ширхэгтэй элс элсэнцэр, сул барьцалдсан хайргажингийн нимгэн үелэл жижиг мишэл тохиолддог.

Туул голын хөндийн хэмжээнд тархсан дөрөвдөгчийн сэвсгэр хурдсыг тэдгээрийн гарал үүсэл, талбайн байршил, мөхлөгийн болон литологийн бүрэлдэхүүний онцлог, давхраажилтын ангилагдсан байдал, зөөгдлийн зэргийг харгалзан дараах хувилбараар тоймлон ангилав. Үүнд:

Намхан хэлхээ уулсын мужийн хажуу энгэр, бэл, хормой болон голын хөндийн дэнжийн хэсэгт зонхилон тархсан делюви-пролювийн гаралтай дунд-дээд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас Туул голын хөндийн ай савын татам болон түүний хажуу жигүүрийн бэсрэг цутгал голуудын хөндий дэх аллювийн гаралтай дээд дөрөвдөгч ба орчин үеийн сэвсгэр хурдас Дээд юрын гүний шургамал чулуулаг нь Улаанбаатар хотын өмнөд дүүрэгт орших нилээд өндөр өргөгдсөн дархан цаазат Богдхан уулын массивыг үүсгэдэг бөгөөд уг массивын чулуулаг зүйн бүрэлдэхүүнд том-дунд мөхлөгтэй хааяа шигтгээлэг лейкократ биотитлог боржин, биотит эвэр хуурмагтай боржин, боржин-диорит ховроор тохиолддог.

Судалгааны талбайд карбоны үеийн сэвсгэр хурдас тархсан байна (Зураг 25).




Зураг 25: Судалгааны талбай түүний орчмын геологийн зураг

Геоморфологи

Судалгааны талбай орчмын бүс нутаг геоморфологийн хувьд газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинжийн элэгдэл, идэгдэл-элэгдэл-хуримтлал болон хуримтлалын төрлийг ялгаж болно. Өндөр уулын бүсийн ус хагалбарын мужид зөвхөн газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн элэгдлийн хэв шинж зонхилж байхад намхан хэлхээ уул, бэсрэг толгодын хажуу ташлаг, энгэр, бэл, хормой болон гуу жалга, дэнжийн мөргөцгийн хэсэгт гадаргуугийн идэгдэл-элэгдэл-хуримтлалын төрөл давамгайлдаг. Харин Туул голын хөндийн ай сав болон хажуу жигүүрийн бэсрэг цутгал голуудын татамд газрын гадаргуугийн хуримтлалын төрөл, үйл явц зонхилдог. Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх бүсийн геоморфологийн нөхцлийн өвөрмөц онцлог, гадаргын хотгор гүдгэрийн динамик хэлбэлзлийг үнэлж тодорхойлоход Туул голын хөндийн морфологи нэлээд чухал үүрэгтэй байдаг. Судалгааны талбай нь Туул голруу түрж тогтсон уулын урд хормойн Дөрөвдөгч орчин үеийн настай дэллюви пролювийн гарал үүсэлтэй хурдас тархсан талбайд байрлах бөгөөд гадаргын налуу хойноос урагш намсаж тогтсон байдаг. Газрын гадаргын хэрчигдлийн хувьд дунд зэрэг боловч газар доорх инженерийн байгууламж, ус зайлуулах шугам хоолой, үерийн хамгаалалтын далан барих, барилгын суурь бэлтгэх үйл ажиллагаанаас геоморфологийн нарийн элементүүд устжээ.

Улаанбаатар хот нь дунд зэргийн хүчтэй хөдлөлт болох өндөр магадлалтай тул газар хөдлөлийн өндөр эрсдэлтэй. Сүүлийн үед Улаанбаатар хот орчмын идэвхжилт ажиглагдаж буй бүс нутгуудад хүчтэй газар хөдлөлтөөр үүссэн Хустай, Эмээлт, Шархай, Авдар, Гүнж, Мөнгөнморьт зэрэг 6 идэвхтэй хагарлуудын бүсийг илрүүлсэн байна.



Зураг 26: Улаанбаатар хот орчимд 2005-2015 онд бүртгэгдсэн газар хөдлөлтийн идэвхтэй хагарлууд ба газар хөдлөлт бүртгэгдсэн цэгүүд

2.6 Газрын доорх ус

Судалгааны талбайн баруун хойд хэсэгт 2023 оны 5 сард өрөмдүүлсэн гүний худагтай.

Худгийн нийт гүн 120 метр, усны тогтоосон түвшин 18 метр, цоногийн ашиглалтын усны ундарга 84 метр, шүүрийг 40-120 метрийн гүнд суурилуулсан байна.

Худгийн усны ерөнхий шинжилгээний үр дүнгээс үзэхэд химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна. Мөн өрөмдөг худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.

2.7 Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс газарзүйн мужлалтаар Хөрс – био уур амьсгалын Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн захын тойрогт хамаардаг.

Улаанбаатар хотод хүн амын суурьшил тэлж, барилгажихын зэрэгцээ хөрсний унаган төрх алдагдан эвдэрч, үржил шимт үе нь бүхэлдээ устан байгалийн унаган ургамалгүй болсоор байна.

Үйлдвэрийн талбайн хөрсний дээжин дэх хүнд элементүүдийн агууламж MNS 5850:2019 стандартын элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт илрээгүй байна.

2.8 Ургамлан нөмрөг

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн зүүн хойд хэсэг нь Монгол орны ургамал-газарзүйн 16 тойргоос Хэнтийн уулын тайгын хамаарагддаг.

Хэнтийн уулын тайгын тойрог буюу Улаанбаатар хотын зүүн хойд болон, хойд нутаг нь *Хуш (Pinus sibirica)*, Сибирь гацуур (*Picea obovata*), Шинэс (*Larix sibirica*), Нарс (*Pinus sylvestris*) зэрэг зүйлүүд зонхилсон шилмүүст болон холимог ой үүсгэсэн уулын тайгын шинжтэй.

Үйлдвэрийн талбайн ихэнх хэсэг хүний болон техникийн нөлөөлөлд бүрэн өртөж ургамалгүй болсон. Тус талбайд бэлчээрийн талхагдлыг илэрхийлэгч хөл газрын ургамал болох Ээрэм шарилж (царван) (*Artemisia macrocephala*), Царвант шарилж (*Artemisia macrocephala*), Адамсын шарилж (*Artemisia Adamsii*), Цагаан лууль (*Chenopodium album*) зэрэг ургамлууд зонхилон ургасан байна.

2.9 Амьтны аймаг

Улаанбаатар хотын хэмжээнд хийсэн амьтны аймгийн судалгаа цөөнгүй бий. Ойн хортон шавжийн бүрэлдэхүүнд 7 баг, 114 зүйл шавж бүртгэгдсэн байна. Хөхтнөөс шавж идэштэн 5, гар далавчтан 4, туулай хэлбэртэн 4, мэрэгчид 19, махан идэштэн 13, туурайтэн 5, мөлхөгч 1, шувуу 322 зүйлийн амьтад байршин амьдардаг болохыг судлаачид (Мэндбаатар, Амгаланбаатар, 1999) судлан тогтоожээ. Дээрх олон зүйлийн амьтаас дурдвал: Дагуур зараа, дагуур огдой, монгол тарвага, орог зусаг, сибирь алагдаага, хадны барагчин, бор туулай, бор гөрөөс, халиун буга, зэрлэг гахай махчдаас үен, өмхий хүрнэ, хярс, үнэг, чоно, мануул зэрэг зүйлийн амьтад өргөн тархалттай амьдардаг.

Улаанбаатар хотын өмнөд хэсэгт хил залгаа орших Богдхан уулын Дархан цаазат газар хийгдсэн судалгаагаар 54 зүйлийн хөхтөн амьтантай гэх боловч сүүлийн жилүүдэд Хүрэн баавгай, Хандгай, Нохой зээх, сохор номин хэмээх 4 зүйл амьтан бүрэн дайжиж харин Усны булга, Янгир зэрэг амьтад нэмэгдэх болжээ (С. Шар нар. 2008). Үүнээс үзвэл Богдхан ууланд 52 зүйл хөхтөн амьтан байна. 2016 оны Нийслэлийн хэмжээнд хийсэн судалгаанд 54 зүйл хөхтөнтэй хэмээгээд тайландаа 26 зүйл амьтныг дурдсан байна (Амьтан асралт ХХК. 2016 он). Харин 2021 онд гүйцэтгэсэн хөхтөн амьтны судалгаагаар Улаанбаатар хот, түүний 9 дүүргийн нутаг 58 зүйл хөхтөн амьтад тархан амьдарч байгааг судлаачид тогтоожээ³.

2.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Судалгааны талбай нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцалгүй. Судалгааны талбайн ойролцоо улсын тусгай хамгаалалтад авсан гурван газар байна.

Хүснэгт 7: Судалгааны талбайн ойролцоо орших улсын тусгай хамгаалалттай газруудын мэдээлэл

#	Тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Нийт талбай, га	Хамгаалалтад авсан тогтоолын дугаар	Судалгааны талбай хүртэлх зай, км
Улсын тусгай хамгаалалттай газар				
1	Богдхан уулын дархан цаазат газар (ДЦГ)	42,192.36	1957 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 31-р тогтоол, 1974 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 248-р зарлиг, 1995 оны УИХ-ын 26-р тогтоол	18.0

³ Авралын эрэлд ХХК, Агнуурын менежментийн Тэх төв ТББ. "Улаанбаатар хот орчмын хөхтөн амьтдын тархац, нөөцийн судалгааны ажлын тайлан", УБ хот 2021 он.

#	Тусгай хамгаалалттай газар нутгийн нэр	Нийт талбай, га	Хамгаалалтад авсан тогтоолын дугаар	Судалгааны талбай хүртэлх зай, км
2	Хустайн нурууны байгалийн цогцолборт газар (БЦГ)	48,889.00	УИХ-ын 1993 оны 11-р сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолоор Хустайн нурууг байгалийн нөөц газрын зэрэглэлээр анх улсын тусгай хамгаалалтад авч, 1998 оны УИХ-ын 115-р тогтоолоор зэрэглэлийг ахиулан байгалийн цогцолборт газар болгожээ.	35.8
3	Чингэлтэй хайрхан уулын байгалийн нөөц газар (БНГ)	4,385.56	2012 оны УИХ-ын 56-р тогтоол	22.5

Эх сурвалж: [Улсын ТХГН-ийн мэдээллийн сан \(eic.mn\)](http://eic.mn)

2.11 Түүх, соёлын өв

Сонгинохайрхан дүүрэг нь нийслэл хотын баруун талд орших Сонгино хайрхан уулын нэрээр нэрлэгдсэн юм. Энэхүү уулын оргил нь далайн түвшнээс 1663 метр өндөр. Уг хайрхан нь арслан савдагтай байсан учир Арсланхайрхан хэмээн нэрлэдэг байсан байна. Чингис хаан нэгэнтээ 8 өрлөг, 13 баатрын хамт өнөөгийн Улаанбаатар хот орших газар буюу үзэсгэлэнт сайхан Алтан тэвшийн хөндийд саатан тухалсан аж. Чингээд Арслан хайрханы бэлээр явж байтал арслан хүрхрэх мэт дуу гарч, хад асга нурав гэнэ. Харин нэг сонгино өнхрөн өнхөрсөөр хааны өлмийд тулж тогтсон тул ихэд бэлгэшээн Сонгино уул хэмээн нэрлэсэн домогтой. Сонгино хайрханы нутагт Хэрэйд ханлиг оршиж байсан ба Сонгины буланд 1949 онд Хэрэйдийн ван хан Тоорилын өргөөний туурийг олсон байна. Тус өргөөнд Тэмүүжин эхнэр хүүхдээ мэргэдүүдээс чөлөөлөхөд туслахыг хүсэж, хар булган дахаа Тоорил ханд өргөж байв. Хэрэйд улс мөхсөний дараа тус өргөөнд Чингис хаан хэсэг сууж байгаад Есүй, Хулан хатдын байнгын харш болон хувирсан байна. Уг тууриас 1949, 1966, 2006 оны малтлагуудаар олон сонирхолтой олдвор илэрч байжээ.

Сонгинохайрхан дүүргийн түүх 1992 онд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу тухайн үеийн Октябрийн районоос өрх тусгааралсанаар эхэлдэг. Монгол УИХ-ын 1992 оны 18-р тогтоолын дагуу Сонгинохайрхан дүүргийн ИТХ 100 төлөөлөгчтэйгээр анхны хуралдаанаа хийж Сонгинохайрхан дүүргийг байгуулах тухай тогтоолыг 1992 оны 10 сарын 1-ний өдөр гаргасанаар тус дүүрэг албан ёсоор байгуулагдсан юм.

Судалгааны талбай орчимд хийгдсэн археологи, палеонтологийн судалгааны мэдээллүүдээс үзэхэд эзэмшил газарт ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна.

2.12 Нийгэм, эдийн засаг

Сонгинохайрхан дүүрэг

Сонгинохайрхан дүүрэг 124362.1 га нутаг дэвсгэртэй. Нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил залган оршдог. Монгол Улсын нийт хүн амын 11.6 хувь, Нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь, орон сууцны хорооллын 27.1 хувь, гэр хорооллын 72.9 хувь тус дүүрэгт байдаг.

Засаг захиргааны анхан шатны нэгж 43 хороотой. Орон сууцны 12 хороо, гэр хорооллын 22 хороо, холимог 9 хороо оршдог. Нийт 335.703 хүн амтай бөгөөд 94132 өрхтэй юм. Дүүргийн газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав бүхий газар, 3 хувийг зам шугам сүлжээ, барилгажсан газар тус тус эзэлдэг. Дүүргийн хэмжээнд 83687 толгой малтай. Үүнээс тэмээ 23, үхэр 26764, адуу 13926, хонь 20917, ямаа 22057 толгой малтай байна.

Сонгинохайрхан дүүрэгт нийт үйл ажиллагаа явуулж байгаа 25865 аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээний дийлэнх хувийг хангадаг Улсын хэмжээний томоохон “Сүү” ХХК, “Талх чихэр” ХХК, “Алтан тариа” ХХК, “Мах импекс” ХХК, “Тесо” ХХК, “Милл хаус” ХХК, “Арвайн үндэс” ХХК зэрэг үйлдвэр, барилгын материалын “Хангай” зах, тоосгоны үйлдвэр болон хүнс худалдаа, үйлчилгээний 12500 гаруй аж ахуй нэгж, байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийн төв, салбар 2 амбулатори, Нэгдсэн эмнэлэг, салбар 1 амбулатори, 26 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон нийт 31 нэгжид 706 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд дүүргийн 342 мянга гаруй иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна.

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо

Тус хороо нь 759 өрхийн 2701 хүн амтай, зүүн хэсгээрээ 22-ын товчоо болон, 20-р хороо, урд талаараа Сонгино хайрхан уулаар, зүүн урдуураа Төв аймгийн Алтан булаг сумын Хустайн нуруу, Хурганы сангийн аж ахуйн баруун талаар Төв аймгийн Баянцогт сумын хүй долоон худаг, хойгуураа Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, зүүн хойд талаараа 22-р хороо тахилтын хэсэгтэй холбогдсон өргөн уудам нутаг дэвсгэртэй. Нутаг дэвсгэр нь тэгш, нам дор байрлалтай ба баруун талаараа чулуурхаг, газрын төлөв байдал чанарт өөрчлөлт ороогүй гадаргатай, голын гольдирул даган үерийн аюул орж болзошгүй бүстэй. Нийт газар нутгийн хэмжээ 235 мянган га газар нутагтай.

Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо нь нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6/48 тоот тогтоолоор 32 дугаар хороо болон зохион байгуулагдсан.

Бордоо, Баруун түрүү, 384 гарам, Эмээлт, Хурган зэрэг 5 хэсэгтэй Тус хороонд “Улаанбаатар буян” ХХК, Сонгинохайрхан үйлчилгээний төв, “Цэцэн хүү”, хүүхдийн цэцэрлэг зэрэг 72 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Ашиглалтын явцад ашиглагдах машин, техник тоног төхөөрөмжөөс ШТМ алдагдаж, газрын гадарга, хэвлийд нэвчин бохирдуулж болзошгүй,
- Үйлдвэрт ашиглах химийн бодисууд санамсар болгоомжгүй байдлаас асгарч алдагдах, химийн бодисын үлдэгдэл агуулж болзошгүй сав баглаа боодол хяналтгүй хаягдсанаас химийн хортой болон аюултай бодисоор газрын гадарга, хэвлий бохирдож болзошгүй,
- Химийн бодис тээвэрлэх явцад төслийн ажилчдын санамсар болгоомжгүй байдал болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэнэтийн осол гарч хортой, аюултай химийн бодис алдагдаж орчны газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй.

3.2 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

- Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрлэлийн явцад агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагаа доголдож болзошгүй бөгөөд үүнээс үүдэн дотоод орчны агаарын чанар муудах, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй
- Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн түүхий эд материал, химийн бодисыг тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч (жилд дунджаар 340 кг), агаарын чанарын найрлагад түр хугацаанд, бага хэмжээгээр нөлөөлнө.
- Хүйтний улиралд үйлдвэрийн халаалтын зуухнаас нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, тоос ялгарч (жилд дунджаар 3.85 тн), агаарын чанарын найрлагад түр хугацаанд, бага хэмжээгээр нөлөөлнө
- Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүд (2 ачааны машин, 1 үйлчилгээний машин)-ийн хөдөлгүүрээс болон халаалтын зуухнаас ялгарах агаар бохирдуулагч бодисууд (CO, SO₂, NO₂, CO₂, PM10, PM2.5 жилд дунджаар 4.2 тн) ялгарч тухайн орчны агаарыг бохирдуулна. Халаалтын зуух болон тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн утаа нь байгаль орчныг бохирдуулах нөлөөлөл үзүүлэх төдийгүй, амьсгал боогдуулагч, хорт хавдар үүсгэгч зэрэг хүний эрүүл мэндэд хортой бодисуудыг агуулдаг бөгөөд агаар мандалд (хүний амьсгалын түвшинд) шууд цацагдаж байдаг. Хүнд даацын машин механизмын хөдөлгүүрээс гарч буй утааны найрлага нь хэрэглэж байгаа шатахуун, тосны төрөл чанар, хөдөлгүүрийн ажиллагааны горим, түүний техникийн байдал, хөдөлгөөний нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

3.3 Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед ШТМ асгарах, химийн бодис тээвэрлэх явцад ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч химийн бодис асгарсан тохиолдолд хөрс бохирдож (тухайн бохирдлыг саармагжуулах, бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд), улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин Туул голын урсцыг бохирдуулж болзошгүй.

3.4 Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хатуу, шингэн хаягдал, техник тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс алдагдах ШТМ болон химийн бодисын үлдэгдэлтэй савнаас химийн бодис алдагдсан тохиолдолд хур борооны үерийн усаар угаагдаж, хөрсөөр дамжин гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

3.5 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагааны үед хөрсөн бүрхэвчид дараах сөрөг нөлөөллүүдийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Үйлдвэрийн түүхий эд материал тээвэрлэх явцад ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл болон байгалийн давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер г.м)-ийн улмаас гэнэтийн осол гарч химийн бодис болон ШТМ асгарч, гоожсон тохиолдолд тухайн орчны хөрсийг бохирдуулж болзошгүй;
- Ашиглалтын явцад химийн бодисын үлдэгдэл агуулж болзошгүй сав баглаа боодол хяналтгүй хаягдах, улмаар химийн бодисын үлдэгдэл хур тунадасны усаар угаагдах, салхиар орчны агаар, хөрсөнд тархах зэргээр агуулахын талбай болон түүний орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй.

3.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Үйлдвэрийн талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ халцарч ургамалгүй болсон тул барилгын болон ашиглалтын үед нөлөөлөлд өртөх ургамлан нөмрөг байхгүй. Иймээс төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

3.7 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Хээрийн судалгаагаар төсөл хэрэгжих талбайд хөхтөн, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид бүртгэгдээгүй ба төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх шууд сөрөг нөлөөлөл байхгүй.

3.8 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцалгүй тул тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

3.9 Дуу шуугианаас үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотойгоор дуу чимээ, чичиргээ доргиотой ажил хийгдэхгүй учир үйлдвэрийн ажилчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

3.10 Нийгэм, эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Эерэг нөлөөлөл

- Тус төсөл хэрэгжсэнээр 44 хүний ажлын байр шинээр нэмэгдэнэ.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Үйлдвэрийн газрын байршил нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” стандартын шаардлагад бүрэн нийцэж байна.

3.11 Түүх, соёлын өвд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн талбай нь хүн амын суурьшилтай ойрхон, Эмээлт үйлдвэрлэлийн бүсэд байрладаг. Төслийн талбай, түүний ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Барилгын ажил хийх явцад түүх соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд ажлыг түр зогсоон холбогдох байгууллагууд руу мэдэгдэх үүрэгтэй.

4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний зорилго нь “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр” төслөөс тухайн газар нутгийн байгаль орчинд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, нөхөн сэргээхэд оршино.

Тус БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон тус журмын 1-р хавсралыг баримтлан боловсруулав.

Тус төслийн 2023-2027 оны хооронд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал гучин таван сая долоон зуун ерэн мянган төгрөг (35,790,000) байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 8. 2023-2027 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	3,100,000
2	Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын зардал	9,000,000
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	0
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	8,640,000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,500,000
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	7,550,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	3,000,000
Нийт дүн		35,790,000

2024 оны төслийн үйл ажилтай холбогдох сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, орчны тохижилт, осол эрсдэл болон хог хаягдлын менежментийн арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс гадна тус БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. 2024 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 7,158,000 төгрөг зарцуулна.

Хүснэгт 9: 2024 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	620,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,800,000
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,728,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	900,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,510,000
6	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө	600,000
Нийт зардал		7,158,000

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг хийхээр төлөвлөв.

Хүснэгт 10: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 он

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Барилгын ажил болон ашиглалтын явцад ашиглагдах машин, техник тоног төхөөрөмжөөс ШТМ алдагдаж, газрын гадаргыг бохирдуулж болзошгүй	Түүхий эд тээврийн хэрэгслүүдийг тусгайлан бэлтгэсэн зогсоолд зогсоох, тээврийн хэрэгслүүдийн шатах тослох материал асгарч болзошгүй эд ангиудад үзлэг, асгарсан тохиолдолд хязгаарлах, цэвэрлэх	Үйлдвэрийн талбайд	төг/жил	300,000	1	300,000		2024 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.3.1 заалт, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журам, 2013
Химийн хортой, аюултай химийн бодис тээвэрлэх явцад алдагдаж орчны газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй	Химийн бодисын асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд асгаралтыг холбогдох хэлтсүүдэд мэдээлэх, шингээх, саармагжуулах арга хэмжээг нэн тэргүүнд авах	Химийн бодис тээвэрлэх зам	Төг/жил	1,420,000	1	(1,420,000)	Асгаралт үүссэн тохиолдолд саармагжуулах бодис, шингээх материалын зардал Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд туссан	2024 онд Химийн бодисын агуулахаас химийн бодис тээвэрлэх үед асгаралт үүссэн тохиолдолд	БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 28/40/29 дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/ Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Дүн						300,000			
ХОЁР. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ	Тээврийн хэрэгсэл сонгон ашиглахдаа тухайн хэрэгслийн үр ашигтай байдал болон түлшний зарцуулалтыг харгалзан үзнэ	Үйлдвэрийн тээврийн хэрэгслүүд	төг/ш	Зардал төлөвлөх шаардлагагүй.	Төслийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдийн тоо		Зардал төлөвлөх шаардлагагүй	2024 онд	
Хэсгийн дүн						-			
ГУРАВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагаа доголдож болзошгүй бөгөөд үүнээс үүдэн дотоод орчны агаарын	Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг ханаж хянаж, стандартад заасан хэмжээнд байлгана	Үйлдвэрийн дотоод орчин	Төг/удаа	160,000	2	320,000		2024 онд	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага-ын 5 болон 6-р хэсэг, MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/ Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
чанар муудах, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй	Үйлдвэрийн түүхий эд арьс ширны хадгалалтын горим алдагдан үйлдвэрийн орчинд үнэр тархаж болзошгүй тул Хими, химийн технологийн хүрээлэнгээс гаргасан үнэр дарагч "ЯХ" хуурай бэлдмэлийг ашиглана.	Үйлдвэрийн дотоод орчин					Үйл ажиллагааны зардал багтсан	2024 онд	MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд, бага хэмжээгээр нөлөөлнө	Тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал утааны шүүлтүүр ашиглах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ	Тээврийн хэрэгслүүд	хүн/сар	1,000,000 (Нэг ажилтны сарын дундаж цалин)	1	(1,000,000)	Үйл ажиллагааны зардалд хамаарна	2024 он	
Хэсгийн дүн						320,000			
ДӨРӨВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед	Тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оношилгоонд тогтмол оруулж, засвар	Тээврийн хэрэгслүүд	хүн/сар	1,000,000 (Нэг ажилтны сарын	1	(1,000,000)	Үйл ажиллагааны зардалд хамаарна	2024 он	

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/ Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
ШТМ, химийн бодис асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсцыг бохирдуулж болзошгүй	үйлчилгээг цаг тухайд нь чанартай гүйцэтгэж байх			дундаж цалин)					
Хэсгийн дүн						(1,000,000)			

ТАВ. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хатуу, хаягдал, хур тунадас орсон үед үерийн усаар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Барилгажилт болон ашиглалтын үед үүсэх хог хаягдлыг цуглуулж, хог гэрээлэгч байгууллагаар тогтмол хугацаанд ачуулна	Барилгажилтын үед төслийн талбайд	Төг/жил				Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд туссан		
	Үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах худгийн ус авах шугамд тоолуур суурилуулна	Худаг	Төг/удаа				Үйл ажиллагааны зардалд туссан	2024 онд	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралт “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Хэсгийн дүн						-			

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/ Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
ЗУРГАА. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Тээврийн хэрэгслүүдээс ШТМ, химийн бодисын үлдэгдэлтэй савнаас химийн бодис алдагдсан тохиолдолд орчны хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй	Химийн бодис шилжүүлэн ачих, тээвэрлэх, хадгалах явцад ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллана.	Химийн бодис тээвэрлэх, шилжүүлэн ачих, хадгалахад оролцож буй бүх ажилчид					Үйл ажиллагааны зардал	2024 он	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” МУ-ын Шадар сайд, БОАЖСайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 тоот хамтарсан тушаалын хавсралт
Хэсгийн дүн						-			
ДОЛОО. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Үйлдвэрийн талбай нь өмнө хөндөгдсөн, байгалийн ургамалжилтгүй талбайд баригдах тул ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Харин орчны тохижуулалтаар тарсан мод, сөөг нөлөөлөлд	Орчны тохижуулалтын хүрээнд тарьсан мод, сөөгийг арчилж тордох	Үйлдвэрийн талбайн хойд хэсэгт ойролцоогоор 100 м ² талбайд тарьсан мод, сөөгүүд	Төг/удаа				Зардлыг “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-нд тусгасан	2024 он	

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар/ Үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
өртөж болзошгүй									
Хэсгийн дүн						-			
НАЙМ. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Хээрийн судалгаагаар төсөл хэрэгжих талбайд хөхтөн, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид бүртгэгдээгүй	Үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй					Зардал төлөвлөх шаардлагаг үй		2024 онд	
Хэсгийн дүн									
ЕС. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР									
Энэ төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх шууд болон шууд бус сөрөг нөлөөлөл байхгүй	Үйлдвэрийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцалгүй					Зардал төлөвлөх шаардлагаг үй		2024 онд	
2024 оны БОХТ-ний нийт зардал						620,000			

6 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн талбайн хойд хэсэгт орчны тохижуулалтын хүрээнд нутгийн унаган мод, сөөгийг ойролцоогоор 100 м² талбайд тарьж ургуулсан. Эдгээр мод сөөгүүдийг арчилж, тордох. Мөн ногоон байгууламжийн талбайг 150 м²-аар нэмэгдүүлэх арга хэмжээ авна (Үйлдвэрийн талбайд тэр бум модны хүрээнд 50 ширхэг мод тарина).

Хүснэгт 11: Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө, 2023-2024 он

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Орчны тохижуулалт	Мод, сөөгийг тарьж ургуулах, арчилж, тордох, (тэр бум модны хүрээнд 50 ширхэг мод тарина)	Үйлдвэрийн талбайн шинээр 150 м ² талбайд мод сөөг тарих болон хойд хэсэгт тарьсан мод, сөөг	Төг/удаа	2	900,000	1,800,000	2024 онд	
2024 оны орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт зардал						1,800,000		

7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн талбайн ойролцоо түүх, соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдвор байхгүй. Тиймээс энэ төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын дурсгалд шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөөгүй.

8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн бүхий л үе шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгав.

Осол, аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилав. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүсэх осол,
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, халдварт өвчин тархалтаас шалтгаалсан осол,
- Аюултай бодис асгарах,
- Байгалийн гамшиг тохиолдох,
- Гал түймэр гарах,
- Хяналтаас гадуурх дэлбэрэлт үүсэх,
- Хаягдал хадгалах байгууламжийн далан нурах, хаягдлын зуурмагийн дамжлага эвдрэх,
- Тээврийн хэрэгслийн осол гарах.

8.1 Баримтлах эрх зүйн баримт бичиг

Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй химийн хорт болон аюултай бодистой холбоотой хууль тогтоомжуудыг биелүүлэх нь хүний эрүүл мэнд байгаль орчин, төслийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Химийн хорт болон аюултай бодистой холбоотой дараах хууль журмуудыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
- Эрүүгийн хууль,
- Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Гамшгаас хамгаалах тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
- Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай,
- Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт, Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам, БОАЖСайд, ГХСайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаал,
- MNS 6458: 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага,
- MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг,
- MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм,
- MNS 12.104-94 Хөдөлмөр хамгааллын стандартын систем,
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага,

Хүснэгт 12: Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, 2024 он

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Аюултай бодис асгарах	Үйлдвэр ашиглах химийн бодисуудыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, ашиглах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулна	Химийн бодисын агуулах	ширхэг	1,728,000-химийн бодисын шингээгч болон саармагжуулагч материалын дундаж үнэ	1	1,728,000	Нийт 1 байршилд жил бүр нэг химийн бодис шингээгч материал төлөвлөсөн	2023-2027	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2 дугаар бүлэг, Рио Тинтогийн удирдлагын тогтолцооны стандарт, E15 - Аюултай материал болон эрдсийн бус хог хаягдлыг хянах, бууруулах, H1 – Химийн хорт болон аюултай бодист өртөх өртөлтийг хянах
Гал түймэр	1. Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах 2. Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах: -Гал түймэртэй тэмцэх хэсгийг гал унтраах мэргэжлийн сургалтад хамруулах, -Тогтмол гал түймэртэй тэмцэх дасгал сургууль зохион байгуулах, -Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, -Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар байрлуулах; галын	Төслийн бүх байгууламжуудад	Төгрөг	1,375,000 - гал унтраах иж бүрдэл 44000 Гал унтраагуур 4 кг 33000 Машины галын хорны багц	1 4 1	(1,375,000) (176,000) (33,000)	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	дохиолол, гал унтраагуул, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх хэрэгтэй. 3. Гал гарсан тохиолдолд: -Галаас яаралтай гарах -Химийн бодис, тэсрэх бодистой ажиллахад тэднийг хадгалах бүх зааврыг хатуу дагаж мөрдөх, тэдгээр бодисыг зохих газарт нь хадгалах -Гал түймрийн үед барилга байгууламж бүрт тохирох зааврыг ашиглах								
Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад Компанийн эрүүл мэндийн ажилтнууд дүгнэлт гаргаж, тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна.	Төслийн бүх байгууламжуудад	Төгрөг	-	-	-	Үйл ажиллагааны зардал, цалингийн зардалд тусгагдсан	2024	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Автомашин осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээний тухай бодлогыг боловсруулж, мөрдөж ажиллах, Нэг буюу түүнээс олон автомашин буюу объектыг хамарсан осол гарсан тохиолдолд компанийн даатгалын журмыг мөрдөнө. Ослын улмаас хүн бэртэж гэмтэх буюу нас барсан тохиолдолд урьд нь тогтоосон эмнэлгийн түргэн тусламжийн журмыг мөрдөнө. Гал түймэр гарвал галын журмыг мөрдөнө.	Төслийн тээврийн хэрэгслүүдэд	Төгрөг	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024	Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 5 дугаар бүлэг, Замын хөдөлгөөний дүрэм Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
2024 оны осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал						1,728,000			

9 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13: Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө, 2024 он

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Аюултай	Аюултай хог хаягдлыг тусгай цэгт хуримтлуулан, гэрээний дагуу аюултай хог хаягдлын дахин боловсруулах болон устгах зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ хийн гэрээний дагуу	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Төг/удаа			500,000	2024 онд	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль

тогтмол хугацаанд нийлүүлэх нь зүйтэй							
Ахуйн	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, Сонгинохайрхан дүүргийн НААҮГ-тай хог тээвэрлэлтийн гэрээ хийн тогтмол хугацаанд ачуулах	Ажилчид	Төг/ удаа	400,000	1	400,000	2024 онд
2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал						900,000	

10 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, илрүүлэх арга хэмжээний үр дүнг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, аргачлал болон холбогдох зардлыг тодорхойлж, ОХШХ-т тусгалаа.

Хүснэгт 14: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэрийн” төслийн 2024 онд хэрэгжүүлэх ОХШХ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
НЭГ. АГААРЫН ЧАНАР							
Орон байрны доторх агаар бохирдуулах бодис, физик нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ -Температур -Агаарын урсгалын хурд -Харьцангуй чийглэг -Нүүрсхүчлийн хий (CO) -Гэрэлтүүлэг	Цельсийн градус, м/с, хувь, мг/м ³ , люкс	Үйлдвэрийн барилга	2	500,000	1,000,000	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	MNS 4585 : 2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хэсгийн дүн					1,000,000		
ХОЁР. ГАЗРЫН ДООРХ УС							
Усны чанарын шинжилгээ (Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Cn, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар)	мг/л, мг-экв/л, ппм, мксм/см	Гүний худгаас	1 удаа	260,000	270,000	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	MNS 0900:2018 (Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ)
Хэсгийн дүн					270,000		
ГУРАВ. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
Хөрсөн дэх хүнд металлууд Ag, Al, As, B, Ba, Be, Bi, Ca, Cd, Co, Cr, Cu, Fe, Ga, Hg, K, La, Mg, Mn, Mo, Na, Ni, P, Pb, S, Sb, Sc, Sr, Th, Ti, Tl, U, V, W, Zn	Үйлдвэрийн талбай	Химийн бодис асгарсан тохиолдолд дээрх давтамж нэмэгдэнэ	1 удаа	240,000	240,000	Химийн бодис асгарсан тохиолдолд компанийн байгаль орчны мэргэжилтний заавраар гүйцэтгэнэ	MNS 2305:1994 (Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам) MNS 5850:2019 (Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ)

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Хэсгийн дүн					240,000		
2024 оны ОХШХ-ийн нийт зардал					1,510,000		

11 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15: “Малын арьс, нэхийнээс үсийг гэмтээлгүйгээр хуурай технологийн аргаар салгах үйлдвэр” төслийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар
БОУАӨЯ -ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газарт	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу	- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө - Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө - ОХШХ - Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө - Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	2024 онд 1 удаа Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна. Ажлын хэсэг тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулна.	600,000	Байгаль орчны хэлтэс	БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар
Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны албанд	Танилцуулга, илтгэл болон тайлан гаргаж хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг байгаль орчны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	1-ээс доошгүй удаа	Үйл ажиллагааны зардал (Тухайн жилийн тайлан, тараах материал хэвлэх болон бусад зардал)	Байгаль орчны хэлтэс, Орон нутагтай харилцах асуудал эрхэлсэн менежер	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
Дүн, төг.				600,000		

100200955402-Шилжүүлгийн мэдээлэл-Банк хооронд

1 мессеж

Худалдаа Хөгжлийн Банк <EBANK@tdbm.mn>
Хэнд: TORGONSHIR.BELTGEL@gmail.com
Cc: EBANK@tdbm.mn

2024 оны тавдугаар сарын 21 16:14

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо:2024.05.21 16:14:50

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын №:163459660

Системийн огноо:2024.05.21

Нэр:ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ ХХК

Илгээгч	Дансны дугаар: 474053351	Нэр ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ ХХК	Дүн 2,065,000.00 MNT	Ханш 1.00
/ хоёр сая жаран таван мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар 100200955402	Банкны нэр Төрийн сан Нэр СХД.БО нөхөн сэргээх баталгаа	2,065,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

ЕВ -Торгон шир бэлтгэл ХХК ийн РД:6675522 МТ-ний барицаа байршуулалт

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: ___ Он ___ Сар ___ Өдөр

Mail_TORGONSHIRBELTG638519048904683158308368_301202.html
9K

Хүсэлтийн лавлах дугаар: 290129003

Татсан огноо: 2024-10-08 16:42

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2905152657 MN890015002905152657	100200955402	1,514,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ	Хүлээн авагчийн нэр СХД, БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний утга Торгон шир бэлтгэл ХХК, РД6675522 БОМТ барьцаа байршуулал Гүйлгээний огноо 2024-10-08	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
ж. алтанчимэг		



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)

№ 0615431

2021 оны 08 сарын 08 өдөр

Улаанбаатар хот, сум

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

60119-ны ажлын гэрээний 1-д багц /эрх бүхий албан тушаалтны харьяалах байгууллага, ажил, нэр, пол, зэрэг/ *М. Дам. эрхэн* би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ..
М. Дам. эрхэн /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн ..
асуудлыг шалгаад ОЛСОН нь:

Холбогдогч /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг/
р.п. 1138532 /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн ..
боллох нь *М. Дам. эрхэн* зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.
Иймд холбогдогч *М. Дам. эрхэн* /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн ..
зүйлийн *2* -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд
заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч *М. Дам. эрхэн* /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн
тусгай ангийн *2-р н. 2-д* /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу *100.000* /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл
оногдуулсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн *500.000* төгрөгийг Төрийн сангийн *107900000602* тоот дансанд, хохирол, нөхөн
төлбөрийн *500.000* төгрөгийг Төрийн сангийн *107900000602* тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг
/улсын төсөвт/ Төрийн сангийн *500.000* тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн
дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн .. /үйл ажиллагаа, эрх/ аль болохыг
зурах/-ыг .. хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.

4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх .. үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан ..
төгрөгийн торгуулийн шийтгэлийг .. хувийг .. хугацааны дотор, .. хувийг .. хугацааны дотор, ..
хувийг .. хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:

- А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/
- Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, гэврийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/
- В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/ ..
/аль нь болохыг доогуур зурах/ ..
/нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон

Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгсэлээс
хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу ..
.. шийдвэрлэсүгэй.

6. Холбогдогч *М. Дам. эрхэн* /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2
дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар *2021.07.21* -ны өдрийн дотор .. үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах,
эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой .. төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар
албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах
шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах
эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан

ТАНИЛЦСАН:

Холбогдогч



М. Дам. эрхэн
(нэр)



М. Дам. эрхэн

ЗХБ-50

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ДААЛГАВАР

2024 оны 08 дугаар
сарын 08-ны өдөр

01-00-01/006/...

Улаанбаатар
хот, сум

Торгон шир бэлтгэл ХХК (РД: 6675522)-д

“Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ
авахуулах тухай”

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагч Ү.Бат-Эрдэнэ би, зөрчлийн 01-00-01/006/... дугаартай гомдол, мэдээлэл (хэрэг)-д хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутагт үйл ажиллагаа явуулж буй 6675522 регистрийн дугаартай Торгон шир бэлтгэл ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй нөхцөл байдал тогтоогдож байх тул Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 500.000 (таван зуун мянга) төгрөгийн шийтгэлийг төрийн сангийн 100900000602 тоот дансанд 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн дотор хийж барагдуулах арга хэмжээг авах, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийн үр дагаврыг арилгахыг Торгон шир бэлтгэл ХХК (РД: 6675522)-д даалгаж байна.

Даалгаврыг 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллахыг Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 14-р хорооны Өгөөмөрийн 73А байрны 43 тоот хаягт оршин суугч (утас:88810054) Торгон шир бэлтгэл ХХК-ийн гүйцэтгэх захирал, хууль ёсны төлөөлөгч Ж.Алтанчимэг-д даалгаж, тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх болохыг мэдэгдэв.

Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээний зардлыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд, 18 насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгч хариуцна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТАН: (Ү.БАТ-ЭРДЭНЭ)
(гарын үсэг) (нэр)

ДААЛГАВРЫГ
ХҮЛЭЭН АВСАН: (Ж.АЛТАНЧИМЭГ)
(гарын үсэг) (нэр)



Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000841479658

Системийн огноо/System Date: 2024.08.22 11:39:34

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5063665966	ТОРГОН ШИР БЭЛТГЭЛ	500,000.00 MNT	1.00
/ Таван зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	90	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100900000602	Хяналт шалгалтын орлого	500,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Торгон шир бэлтгэл ХХК рд:6675522

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
32 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА
ТОДОРХОЙЛОЛТ**

384 дүгээр гарам, 29 дүгээр гудамж, 32 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18411
Утас: (976) 9929 1560
Цахим хуудас: www.shd.mn

2024.10.08 № 1552

**БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД**

Тус хорооны Эмээлт 413А тоотод байрлах
“Торгон шир бэлтгэл” ХХК (РД:6675522) нь арьс шир
боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг
бөгөөд 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй болохыг
тодорхойлов.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ӨВЛӨН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* С.УЯНГА

